

## НООС БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

Ноос боловсруулах салбарт хивс үйлдвэрлэх 2 үйлдвэр, 4 нэхэх үйлдвэр, 9 ээрэх үйлдвэр, нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх 1 үйлдвэр, 25 угаах үйлдвэр, 23 хялгас ялгах үйлдвэр, 56 сүлжих үйлдвэр, эсгий эдлэл үйлдвэрлэх 16 үйлдвэр, ноосон бордоо үйлдвэрлэх 1 үйлдвэр, 120 эсгийлэх үйлдвэр нийт 257 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

2011 онд батлагдсан “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 30-р тогтоол нь ноос боловсруулах салбарт шинэ эрин үеийг авчирсан, түүнийг сэргээн хөгжүүлэх боломжийг нээж өгсөн түүхэн ач холбогдолтой бөгөөд уг тогтоолыг хэрэгжүүлснээр үндэсний үйлдвэрүүд түүхий эдийн хомсдлоос гарч, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж үйлдвэрлэгчид бүтээгдэхүүн үйлдвэрлэлт болон тухайн жилийн хэрэгцээт түүхий эдийн нөөц, түүхий эд бэлтгэлийн ажлаа төлөвлөх гүйцэтгэх улмаар техник технологийн шинэчлэлт хийх, шинээр үйлдвэр байгуулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болсон.

”Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2011 оны 6-р сарын 03-ны өдрийн 30-р тогтоолоор дараах шийдвэрүүдийг гаргаж хэрэгжүүлсэн. Үүнд:

1) Мал аж ахуйн гаралтай түүхий эдээр үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгосон. Уг тогтоолын дагуу 2011-2013 онуудад ноос боловсруулах салбарын 24 үйлдвэрт 31,1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдож үйлдвэрүүд тоног төхөөрөмжийн шинэчлэлд 12,9 тэрбум төгрөг, үйлдвэрийн өргөтгөл засварт 5,1 тэрбум төгрөг, эргэлтийн хөрөнгө худалдан авахад 13,1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2) Хонь тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд төрөөс мөнгөн урамшуулал олгож эхэлсэн. Уг тогтоолын дагуу 2011-2019 онуудад үндэсний үйлдвэрт ноос тушаасан малчдад 196,5 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Он	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Малчны тоо	32977	103162	117667	80619	79407	92885	86985	49625	46828
Олгогдсон урамшуулал	9,8	29,4	36,6	18,3	19,3	22,6	22,5	18,6	19,4

”Үйлдвэрлэлийг дэмжих тухай” Засгийн Газрын 2013 оны 4-р сарын 13-ны өдрийн 141-р тогтоолоор ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх санхүүжилтийн эх үүсвэрийн гуравны нэгтэй тэнцэх 45 сая хүртэлх ам.долларын (70,7 тэрбум төгрөг) зээл олгохоор шийдвэрлэсэн. Уг тогтоолын дагуу 2015 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар нийт 17 үйлдвэрийн төсөлд 48,2 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

”Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2011 оны 30-р тогтоол болон ”Үйлдвэрлэлийг дэмжих тухай” Засгийн Газрын 2013 оны 141-р тогтоол хэрэгжилтийн үр дүнд ноос боловсруулах салбарт техник технологийн шинэчлэлт хийгдэж ололт амжилт бий болсоор байгаа бөгөөд 2012-2019 онуудад ноос боловсруулах салбарт шинээр 1882 ажлын байр нэмэгдэж нийт 278,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт оруулсан байна.

### 1. Анхан шатны боловсруулах үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт

Хөдөө орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн түүхий эд бэлтгэх, түүхий эд бэлтгэлийн өртөг зардлыг бууруулах, анхан шатны боловсруулалт хийгдээгүй малын гаралтай түүхий эдийг нийслэл хотод боловсруулахыг зогсоох зорилтыг холбооноос тавьж Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байсан угаах

Үйлдвэрүүдийг орон нутаг руу нүүлгэн шилжүүлж мөн орон нутагт шинээр үйлдвэрүүд ашиглалтанд орсноор 13 аймагт ноос угаах 14 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй угаах үйлдвэрүүдэд Монгол Улсаас жилд бэлтгэгдэж байгаа нийт ноосон түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх хүчин чадал суурилагдаж улирлын чанартай 500-600 ажлын байрыг орон нутагт шинээр бий болгосон. Эдгээр 14 үйлдвэрээс 5 үйлдвэрийг нь Улаанбаатар хотоос нүүлгэн шилжүүлсэн бөгөөд 9 үйлдвэрийг шинээр байгуулахад нийт 23,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт оруулсан байна.

Улаанбаатар хотоос ноос угаах үйлдвэрүүдийг орон нутаг руу нүүлгэн шилжүүлж мөн шинэ угаах үйлдвэрүүдийг орон нутагт байгуулж байгаа нь “Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ноос боловсруулах анхан шатны үйлдвэрүүдийг хотын төвлөрсөн хэсгээс гаргах тухай” Монгол Улсын Засгийн Газрын бодлого шийдвэр болон малын гаралтай анхан шатны боловсруулалт хийгдээгүй ноосон түүхий эдийг Улаанбаатар хотод оруулахгүй байх тухай “Ноос боловсруулах үйлдвэрүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Нийслэлийн Засаг Даргын 2015 оны А/230 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээн дэх Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн ачааллыг бууруулах зорилттой нь уялдаж байна.

## 2. Хялгас ялгах үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт

Монгол хонины ноос, тэмээний ноос, сарлагийн хөөврөөс ноолуур үсийг ялгах технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж самнах үйлдвэрүүд хүчин чадлаа нэмэгдүүлж мөн шинээр самнах үйлдвэрүүд ашиглалтанд орж эхэлснээр хялгас ялгах хүчин чадал 2012-2020 онуудад 5,9 дахин нэмэгдсэн байна.

Хялгас ялгах хүчин чадал нэмэгдэж эхэлснээр үйлдвэрлэгчид самнасан ноос, хөөврийг экспортод гаргах улмаар нарийн ээрмэл, сүлжмэл, нэхмэл, ноосон оёмол зэрэг шинэ экспортын шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж бүрдэж байна.

Самнах үйлдвэрүүд ашиглалтанд орж эхэлснээр жилийн 4 улиралд тогтмол байнгын ажиллагаатай үйлдвэрүүдийн тоо нэмэгдэж эдгээр үйлдвэрүүд нийт 300-400 ажлын байрыг шинээр бий болгож, 2012-2019 онуудад хялгас ялгах үйлдвэрлэлд дотоод гадаад эх үүсвэрээс нийт 109 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт орсон байна.

Гэвч гадаад дотоод зах зээлийн эрэлтээс хамаарч самнах үйлдвэрүүд суурилагдсан хүчин чадлынхаа 30%-ийг ашиглаж байгаа нь учир дутагдалтай байна. Үүнд дараах шалтгаан нөлөөлж байна.

- а) Гадны хөрөнгө оруулалттай угаах үйлдвэрүүд түүхий эдийг угаагаад гаргаж байна.
- б) Түүхий эдийн зах зээлийг хамгаалах, ажлын байрыг нэмэгдүүлэх хууль эрх зүйн орчин хангалтгүй
- в) Гадаад дотоод зах зээл дэх ноосон бүтээгдэхүүний борлуулалт хангалтгүй

Цаашид төрөл бүрийн зориулалтаар ашиглагдах самнасан ноосны болон бусад нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор ноос боловсруулах салбарын үйлдвэрлэлд одоо мөрдөгдөж байгаа хонь тэмээний ноос, сарлагийн хөөврөн бүтээгдэхүүний зарим стандартыг шинэчлэх, шаардлагатай байгаа стандартыг шинээр боловсруулж батлуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбооноос 2020 онд байгуулан ажиллаж байна.

## 3. Ээрэх, будах үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт

Манай улс зах зээлээс өмнөх нийгэмд 24/2 хүртэл номерын утас үйлдвэрлэдэг байсан бол УИХ-ын 30-р тогтоолын хэрэгжилтийн үр дүнд ээрэх үйлдвэрүүд техник технологийн шинэчлэлт хийж сүлжмэлийн зориулалттай 26/2-48/2, нэхмэлийн зориулалттай 18/1-80/3 номерын утас үйлдвэрлэх хүчин чадал шинээр суурилуулж манай орны ээрмэлийн үйлдвэрлэл дэлхийн зах зээлийн өнөөгийн шаардлагын түвшинд хүрсэн.

Ээрэх үйлдвэрлэлд 108 ажлын байр шинээр бий болж, 16 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Нарийн ээрэхийн техник, технологи, химийн инженерийн багийг

бүрдүүлж энэхүү технологийг Монгол Улсдаа нутагшуулсан нь ноос боловсруулах салбарт гарч буй томоохон ололт амжилтын нэг юм.

Олон улсын чанар стандартын шаардлага хангасан будах цехүүдийг шинээр ашиглалтанд оруулснаар хэрэглэгч захиалагчдын хүссэн өнгөөр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг бүрдүүлж байна.

#### 4. Хивсний үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт

Монгол Улсын хэмжээнд өнөөгийн байдлаар 1,950.0 мян.м<sup>2</sup> хивс үйлдвэрлэх хүчин чадал суурилагдсан боловч гадаад дотоод зах зээл дэх борлуулалтаас хамаарч хүчин чадлын 50% нь ашиглагдаж байна. Урамшууллын бодлого хэрэгжих хугацаанд түүхий эдийн чанар сайжирснаар 8-12 өнгөөр нэхдэг хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлэн дэлхийн жишигт нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Үүнд:

✓ Бельги улсын Van de wiele фирмийн UC103 маркийн 5м өргөнтэй, 1м<sup>2</sup>-д 1,0-1,2 сая үслэг гогцоотой, өндөр нягттай, дээд зэргийн чанартай хивс үйлдвэрлэдэг нэхэх машиныг Азийн орнуудаас анх удаа Монгол Улсад суурилуулсан.

✓ Хивс нэхэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Герман Улсад үйлдвэрлэсэн нягтаас нь хамааран 1 цагт 9,6-16 м<sup>2</sup> хивс нэхэх өндөр хүчин чадалтай ALPNA-300 маркийн машиныг Монгол Улсад анх удаа суурилуулснаар хөдөлмөрийн бүтээмжийг 2-3 дахин нэмэгдүүлэх боломжтой болсон.

✓ Хивсний үйлдвэрлэлд Францын Шлюмберже компанид үйлдвэрлэсэн хамгийн сүүлийн үеийн автомат тохиргоотой ERA маркийн нарийн зүүт самнах машиныг шинээр суурилуулан ашиглалтанд оруулснаар ноосны бөл цөл, жигд бус, хогт хольц, богино ширхэгтийн хэмжээ багасч, жигдлэг сайн чанарын ээрмэл үйлдвэрлэх боломжтой болсон.

✓ Хивсний үндсэн сүлжээний бөхөлгөөг бүрдүүлдэг импортын олсон ба хөвөн утасны оронд дотоодод үйлдвэрлэсэн ноосон үслэг утсыг ашиглаж, 100% цэвэр ноосон хивс гэдгээрээ хэрэглэгчдийн сонирхлыг ихээр татсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтой болсон.

✓ Монголдоо хамгийн өндөр нягтралтай 1м<sup>2</sup>-д 680,000 ширхэг хатгаштай Улаанбаатар нэр төрлийн хивсийг чанартай нарийн утсаар дахин үйлдвэрлэж эхэлсэн.

✓ Турк улсын Ентема компанид үйлдвэрлэсэн SMELL SOFT маркийн очёс /сэв үс/ цэвэрлэх машиныг хивсний үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг өсгөх боломжтой болсон.

#### 5. Эсгий, ноосон дулаалга, бордооны үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт шинэчлэлт

Монгол Улсын хэмжээнд нойтон аргаар үйлдвэрлэл явуулдаг 120 эсгийний үйлдвэр, хуурай аргын шивэх технологитой 1 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. УИХ-ын 2011 оны 30-р тогтоол гарч ноос бэлтгэн авах боломж бүрдсэнээр хөдөө орон нутагт 70 гаруй эсгий, эсгий эдлэлийн жижиг үйлдвэр шинээр ашиглалтанд орсон нь орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлж ажилгүйдлийг бууруулах, өртөг багатай, чанартай бүтээгдэхүүнээр орон нутгийн хэрэглэгчдийг хангахад хувь нэмрээ оруулж байна.

Ноос, бодын хөөвөр, хонь тэмээ ямааны хялгас, зумалсан ноос, сэв хялгас зэрэг түүхий эдийг ашиглан ноосыг дулааны аргаар боловсруулан төрөл бүрийн зориулалтын 1,620,000 м<sup>2</sup> ноосон дулаалга үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрүүд шинээр ашиглалтанд орж 2011-2019 онуудад эсгий, ноосон дулаалгын үйлдвэрлэлд 10,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 460 ажлын байр шинээр бий болгосон байна.

Ноосон дулаалгын үйлдвэрлэл импортыг орлох, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж байна. Япон зэрэг орнууд манай үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг сонирхож дээжийг нь өөрийн орондоо туршиж шинжилж байна.

Угаах үйлдвэрүүдийн ангилан ялгасан ноосыг ашиглан жилд 2000 тн хонины ноосон био бордоо үйлдвэрлэх үйлдвэр дэлхийд 2 дахь удаагаа, Монгол Улсад анх удаа ашиглалтанд орж 14 ажлын байрыг шинээр бий болгон экспортыг нэмэгдүүлэх шинэ нэр

төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжийг бүрдүүлж улмаар түүхий эдийн ашиглалтыг нэмэгдүүлэх боломжтой болсон.

#### 6. Нэхэх сүлжих үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт

2011-2019 онуудад нийт 391,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай сүлжих үйлдвэрүүд шинээр ашиглалтанд орж, 1,000,000 ширхэг ноосон оймс үйлдвэрлэх хүчин чадал шинээр суурилагдаж олон зуун ажлын байрыг бий болгож, нэхэх үйлдвэрүүд шинэ техник технологи үйлдвэрлэлд нэвтрүүлснээр эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлж байна. Үүнд:

✓ Герман Улсад үйлдвэрлэсэн Dorner, СТМ маркийн нэхэх машинуудын удирдлагын системийг шинэ дэвшилтэт технологиор сольж өөрчилснөөр программаас шалтгаалан гардаг гэмтэл сул зогсолт багасч хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлсэн.

✓ Нанотехнологийн аргаар ус, хог болон шингэний гаралтай бохирдлыг шингээдэггүй өвөрмөц шинж чанартай даавуу (smart textile) гарган авах технологийг Монгол Улсад нутагшуулан Герман Улсын Котема фирмд зохион бүтээсэн 1 цагт 300 м даавуунд нано боловсруулалт хийх хүчин чадалтай шугамыг суурилуулан ашиглалтанд оруулсан ба уг машин дээр гэрийн бүрээсний зориулалттай даавуу боловсруулахаас гадна нанотехнологийн аргаар ус үл нэвчих хучлага, уул уурхайн ажлын хувцасны зориулалттай материалыг үйлдвэрлэх боломжтой.

✓ Жилд 500,000 уртааш метр ноосон даавуу үйлдвэрлэх, даавууны гүйцэтгэн боловсруулалт хийх иж бүрэн шугам шинээр суурилагдаж, монгол хонины ноосоор даавуу үйлдвэрлэх боломжтой болсон.

✓ Сүлжих үйлдвэрлэлд Герман Улсад үйлдвэрлэгдсэн STOLL фирмийн бүрэн автомат сүлжих машин суурилуулагдсанаар хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж нэмэгдсэн.


✓ Сүлжих үйлдвэрлэлд БНХАУ-д үйлдвэрлэгдсэн бүрэн автомат сүлжих машинууд болон гүйцэтгэн боловсруулалтын тоног төхөөрөмжүүд суурилуулагдсанаар үйлдвэрлэлтийн хугацааг богиносгож, эцсийн бэлэн бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх боломжтой болгосон.

### ХҮЧИН ЧАДЛЫН ӨСӨЛТ: 2011 – 2020 ОН


Ноос боловсруулах салбарт 2020 оны байдлаар 1.6 сая.м<sup>2</sup> хивс, 71,400 тн ноос угаах, 3,289 тн самнасан ноос үйлдвэрлэх, 3,293 тн ээрмэл, 1,243,000 ширхэг сүлжмэл, 2,500,000 ширхэг ноосон оймс, 817,0 мян.м<sup>2</sup> нэхмэл, 500,0 мян.м<sup>2</sup> ноосон даавуу, 1,260.0 мян.м<sup>2</sup> нэхээсгүй эдлэл, 4,106.7 мян.м<sup>2</sup> эсгий, 1,620 мян.м<sup>2</sup> дулаалгын материал, 2000 тн ноосон бордоо үйлдвэрлэх хүчин чадал суурилагдсан байна.

Д/д	Дамжлага	Хэмжих нэгж	Суурилагдсан хүчин чадал: 2011 он	Нэмж суурилагдсан 2012-2020	Суурилагдсан хүчин чадал: 2020 он	Өсөлт %
1	Угаах	мян.тн	25.0	46.4	71.4	185,6
2	Хялгас ялгах	тн	552.0	2,737.0	3,289.0	495,8
3	Ээрэх	тн	2,763	530	3,293	19,2
4	Сүлжих	мян.ш	852.0	391.0	1,243.0	45,9
5	Сүлжих /оймс	мян.ш	1,500.0	1,000.0	2,500.0	66,7
6	Нэхэх	мян.м <sup>2</sup>	557.0	260.0	817.0	46,7
7	Эсгийлэх	мян.м <sup>2</sup>	3,147.5	959.2	4,106.7	30,5
8	Ноосон дулаалга	мян.м <sup>2</sup>	-	1,620.0	1,620.0	100
9	Ноосон даавуу	мян.м <sup>2</sup>	-	500.0	500.0	100
10	Ноосон бордоо	тн	-	2,000	2,000	100


Угаах үйлдвэрлэл




Хялгас ялгах үйлдвэрлэл




Ээрэх үйлдвэрлэл




Нэхэх үйлдвэрлэл



Сүлжих үйлдвэрлэл /оймс



Сүлжих үйлдвэрлэл





## ХҮЧИН ЧАДАЛ АШИГЛАЛТЫН ТҮВШИН 2020 ОНЫ БАЙДЛААР:

Ноосны урамшуулал хэрэгжиж эхэлснээс хойш тус салбарт хийгдэж буй техник технологийн шинэчлэлт, бий болж байгаа ололт амжилтуудын үр дүнд “Монгол Улсын тогтвортой байдлын үзэл баримтлал 2030”-д заасан ноос ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшинг 2021 онд 60%-д, 2030 онд 80%-д хүргэх зорилтыг хэрэгжүүлэх үндэс суурь тавигдсан.

Гэвч улс орны нийгэм эдийн засгийн байдал, хүн амын орлогын түвшин, гадаад дотоод зах зээл дэх борлуулалт харьцангуй бага байгаа зэрэг нөхцөлүүдийн улмаас үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадал үйлдвэрлэлийн төрлөөсөө хамааран 5-61%-ийн ашиглалттай байна.

Энэхүү хүчин чадлын ашиглалтыг авч үзвэл угаах 41 хувь, самнах 51 хувь, ээрэх 46 хувь, сүлжих, нэхэх 48 хувь, хивс 45 хувь, нэхээсгүй эдлэл 57 хувь, эсгий 61 хувь, ноосон дулаалгын материал 5 хувийн ашиглалттай байна. Дотоодод үйлдвэрлэгдэж байгаа бүтээгдэхүүнтэй ижил төстэй бараанууд импортоор их хэмжээгээр орж ирэн төрийн байгууллагуудын болон иргэдийн хэрэгцээнд зориулагдан борлуулагдаж байгаа ба хямд үнэтэй импортын бараатай дотоодын үйлдвэрүүдийн өрсөлдөх чадвар сул байна.



## ТҮҮХИЙ ЭДИЙН НӨӨЦ 2011-2020 ОНЫ БАЙДЛААР:

Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжиж ноос тушаасан малчдад мөнгөн урамшуулал олгох тухай тогтоолууд хэрэгжиж эхэлснээр малчдын ноосноос олох орлого нэмэгдэж улмаар хонь тэмээн сүргээ өсгөх сонирхол нэмэгдсэн нь түүхий эдийн нөөцийг нэмэгдүүлэх эерэг үр дагаврыг бий болгосон. Ноосны урамшуулал хэрэгжиж эхэлснээс хойш хонь болон тэмээн сүргийн тоо жилээс жилд тасралтгүй өсч 2010 онд тоологдсон хонь тэмээний тоотой харьцуулахад 2019 онд хонь 129.7%-иар, тэмээ 78.1%-иар тус тус өссөн байна.


Малын төрөл	Нэгж	2010	2011	2012	2013
Хонь	мян.толгой	14,050.8	15,668.5	18,141.4	20,036.6
Тэмээ	мян.толгой	265.3	280.1	305.8	321.0

Малын төрөл	Нэгж	2014	2015	2016	2017
хонь	мян.толгой	23,214.8	24,943.1	27,853.4	30,109.89
тэмээ	мян.толгой	349.3	368.0	401.3	434.1

Малын төрөл	Нэгж	2018	2019		
хонь	мян.толгой	30,553.5	32,267.3		
тэмээ	мян.толгой	459.7	472.4		


### ХОНИНЫ НООС БЭЛТГЭЛИЙН ХЭМЖЭЭ: 2011-2019 ОН

Хонины ноос /бэлтгэсэн он	МУ-ын ноосны нөөц /мян.тн	Үйлдвэрүүдийн бэлтгэсэн хэмжээ /мян.тн	Бэлтгэсэн хэмжээ /нөөцөд эзлэх %
2011	16,9	4,7	27,8%
2012	18,8	15,7	83,5%
2013	21,8	18,9	86,7%
2014	24,1	21,1	87,6%
2015	27,9	18,1	64,9%
2016	29,9	21,6	72,2%
2017	33,4	20,5	61,4%
2018	36,1	16,7	46,3%
2019	36,7	13,3	36,2%



### ТЭМЭЭНИЙ НООС БЭЛТГЭЛИЙН ХЭМЖЭЭ: 2011-2019 ОН

Тэмээний ноос /бэлтгэсэн он	Ноосны нөөц /мян.тн	Үйлдвэрүүдийн бэлтгэсэн хэмжээ /мян.тн	Бэлтгэсэн хэмжээ /нөөцөд эзлэх %
2011	1,1	0,2	18,2%
2012	1,1	1,0	90,9%
2013	1,2	1,2	100%
2014	1,3	1,1	84,6%
2015	1,4	0,9	64,3%
2016	1,5	1,1	73,3%
2017	1,6	1,2	75%
2018	1,7	0,8	47,1%
2019	1,8	0,4	22,2%



2011-2019 онуудад үндэсний үйлдвэрт ноос тушаасан малчдад 196,5 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон түүнчлэн үндэсний үйлдвэрүүд малчин, мал бүхий этгээдээс 260,4 тэрбум төгрөгөөр ноосон түүхий эд худалдан авсан ба ноосны урамшууллын бодлогын үр дүнд өнгөрсөн хугацаанд нийт 456,9 тэрбум төгрөг малчдад ахуй амьдралд нь эерэг нөлөө үзүүлсэн томоохон хөрөнгө оруулалт болон очсон бөгөөд энэхүү хөрөнгө оруулалт нь малчдаар дамжин боловсрол, аж үйлдвэр, эрүүл мэнд, гадаад худалдаа, банк санхүүгийн зэрэг олон салбарт хөрөнгө оруулалт болон орж байна.

#### БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ: 2011 – 2019 ОН

Монгол Улсаас жилд бэлтгэгдэж байгаа ноосон түүхий эдийн нөөц нь үндэсний үйлдвэрүүдийн жилийн нийт хэрэгцээний 65-70%-тай тэнцэх хэмжээтэй байдаг. Түүхий эдийн хүрэлцээ хангамж, бүтээгдэхүүн борлуулах дотоод гадаад зах зээлийн багтаамж, улс орны нийгэм эдийн засгийн байдал, хүн амын орлогын түвшин зэрэг нөхцөлүүд нь үйлдвэрлэлтийн хэмжээнд нөлөө үзүүлж байна.

Д/д	Нэр төрөл	Хэмжих нэгж	2011	2012	2013	2014
1	хивс	м <sup>2</sup>	871,720.6	919,259.3	857,535.9	725,400.0
2	нэхмэл	ш	40,200.0	48,660.0	53,805.0	58,321.0
3	сүлжмэл	ш	45,750.0	79,890.0	170,942.0	202,570.0
4	ээрмэл	тн	1,439.1	2,721.6	2,836.5	2,343.5
5	эсгий	м	677,733.0	1,040,478.0	1,072,000.0	1,502,300.0
6	эсгий эдлэл	ш	147,330.0	198,345.0	209,353.2	174,063.0
7	угаасан ноос	тн	4,116.8	6,967.8	4,392.5	4,301.9
8	самнасан ноос	тн	82,7	586,4	725,3	504,9

	Нэр төрөл	Х.нэгж	2015	2016	2017	2018	2019
1	хивс	м <sup>2</sup>	678,392.4	449,787.6	465,000.0	498,950.0	448,299.8
2	нэхмэл	ш	70,120.0	63,500.0	52,879.0	70,678.0	14,233.0
3	сүлжмэл	ш	316,787.0	424,900.0	310,042.0	92,739.0	45,420.0
4	ээрмэл	тн	2,211.3	1,409.0	831.0	927.0	181.3
5	ноосон даавуу	м				23,000	5.0
6	ноосон оёмол	ш				26,161	39,144.0
7	ноосон оймс	хос				122,400	888,000.0
8	эсгий	м	1,350,200.0	1,230,250.0	1,360,900.0	1,398,100.0	1,413,200.0
9	эсгий эдлэл	ш	105,553.0	151,572.0	124,951.0	49,182.0	64,709.0
10	угаасан ноос	тн	4,198.5	6,677.0	1,563.0	1,613.8	173.3
11	самнасан ноос	тн	710.1	803.7	1,264.6	424.3	557.5

#### ЭКСПОРТ - 2018-2019 ОНД:

Сүүлийн 2 жилийн байдлаар үндэсний үйлдвэрлэгчид 2018-2019 онд хонь тэмээний ноосон 10 нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортод гаргасан байна.

Д/д	Нэр төрөл	Хэмжих нэгж	2018	2019
1	хивс	мян.м <sup>2</sup>	30.6	38.8
2	нэхмэл	ш	3,622	-
3	сүлжмэл	ш	12,900	8,666
4	ээрмэл	тн	0.1	0.7
5	ноосон оймс	ш	122,400	834,000
6	ноосон оёмол	ш	1,000	460
7	ноосон бордоо	тн		5.0
8	эсгий шаахай	ш	31,560	26,057
9	эсгий эдлэл	ш	3,193	4,817
10	самнасан ноос	тн	604.1	192.8